

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн сайд (цаашид “Сайд” гэнэ), нөгөө талаас Тогтвортой байдлын гэрээ байгуулах хүсэлт гаргасан Монгол Улсад үүсгэн байгуулагдсан компани бөгөөд аж ахуйн нэгжийн 2073765 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн 99-206 дугаартай гэрчилгээтэй Монгол Улсын нутаг дэвсгэрт Бетон зуурмагийн үйлдвэрлэл болон барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хөрөнгө оруулагч “Суруга Монгол” ХХК-ийн (цаашид “Хөрөнгө оруулагч” гэнэ) үйл ажиллагаа явуулах орчин, дээрхи гэрээний нөхцөл, заалтуудыг тодорхой хугацаанд тогтвортой байлгах баталгаа болгож энэ гэрээ (цаашид “Энэхүү гэрээ” гэнэ)-г байгуулав.

### Нэг.Гэрээгээр зохицуулах зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь хөрөнгө оруулагч Монгол Улсын Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших “Дөрвөн улирлын цэцэрлэг” төслийн үйл ажиллагаа (нийтийн орон сууц, амины орон сууц, оффисийн барилга, сургууль, эмнэлэг, худалдааны төв, зочид буудал, амралт чөлөөт цагийн төв, дэд бүтэц, шугам сүлжээний төрөл бүрийн угсралтын ажил гэх мэт, борлуулалт, эзэмших болон түрээслэх), хүчитгэсэн бетон эдлэл, бетон зуурмаг, тусгай цементийн төрөл бүрийн үйлдвэрлэл болон борлуулалт, түүнээс бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх барилгын болон дэд бүтэц, шугам сүлжээний угсралтын ажил зэргийг явуулахад нь тогтвортой орчноор хангахад орших бөгөөд хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, энэхүү гэрээг дуусгавар болгох үндэслэл, хэрэгжүүлэх хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулсан анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 16.5 тэрбум төгрөг байгаа тул Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дугаар заалтын дагуу энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш 15 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар байгуулав.
- 1.3. Хөрөнгө оруулагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чөлөөтэй борлуулах, Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөгийн болон гадаад валютын борлуулалтын орлогоо чөлөөтэй ашиглаж болох хууль, эрх зүйн баталгаат нөхцөлөөр хангана.
- 1.4. Энэхүү гэрээ нь компаний үндсэн үйл ажиллагаанд хамаарна.

### Хоёр. Татварын орчин

- 2.1. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан татваруудыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх

- хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээгээр төлнө.
- 2.2. Хөрөнгө оруулагч өөрийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бүх төрлийн бараа бүтээгдэхүүн, боловсруулсан бүтээгдэхүүн болон ажил үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээгээр ногдуулна.
  - 2.3. Хөрөнгө оруулагчийн өөрийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор импортлосон бүх төрлийн авто бензин, дизель түвшинд авто бензиний болон дизель түлшний татвар, онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээний дагуу ногдуулна.
  - 2.4. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцон Монгол Улсад байнга болон түр хугацаагаар оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэд хувь хүний орлогын албан татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээний дагуу төлнө.
  - 2.5. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцож байгаа Монгол Улсын иргэд хувь хүний орлогын татварыг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан татварын хувь хэмжээгээр төлнө.
  - 2.6. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч Монгол Улсад олсон дараах орлогод энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан татварын хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:
    - 2.6.1. Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого,
    - 2.6.2. Зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр,
    - 2.6.3. Эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, удирдлагын зардалд төлсөн төлбөр, түрээсийн төлбөр, биет ба биет бус хөрөнгө ашиглуулсны орлого,
    - 2.6.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого.
  - 2.7. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж олсон тухайн ашгаа гадаад руу шилжүүлбэл шилжүүлсэн ашгаас энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд заасан татварын хувь хэмжээгээр албан татвар ногдуулна.

- 2.8. Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн энэхүү гэрээний заалт нь тогтвортой мөрдөгдөнө. Гэхдээ энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Хөрөнгө оруулагчид энэхүү гэрээнд заасан бүх нөхцлөөс илүү таатай нөхцөл олгох аливаа хууль, тогтоомж, олон улсын гэрээ ( цаашид “хууль тогтоомжууд”гэнэ ) Монгол Улсад батлагдаж, тухайн таатай нөхцлийг эдлэх хүсэлтээ Хөрөнгө оруулагч Сайдад бичгээр гаргасан тохиолдолд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Тухайн нэмэлт, өөрчлөлт орсон өдрөөс эхлэн Хөрөнгө оруулагч уг таатай нөхцлийг эдлэх болно.

### **Гурав.Газрын харилцаа**

- 3.1. Хөрөнгө оруулагч нь үндсэн үйл ажиллагаандаа шаардагдах газар ашиглахтай холбоотой холбогдох зөвшөөрөл, лицензийг Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан журмын дагуу авна.
- 3.2. Газар ашигласны төлбөрийг Газрын тухай болон Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу тогтоох бөгөөд тухайн төлбөр нь энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсан хуульд заасан хэмжээгээр төлнө.

### **Дөрөв.Байгаль орчин**

- 4.1. Хөрөнгө оруулагч нь өөрийн эзэмшил талбайд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.2. Хөрөнгө оруулагч нь өөрийн эзэмшил талбайд байгаль орчныг хамгаалах жил бүрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах бүхий л хөрөнгийг хариуцна.
- 4.3. Хөрөнгө оруулагчийн хүсэлтийн дагуу ус ашиглах гэрээг, Усны тухай хууль, Усны төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу байгуулна.
- 4.4. Хөрөнгө оруулагч нь өөрийн эзэмшил талбайд эдэлбэр газрын экологи эдийн засгийн үнэлгээ, байгалийн нөөцийн даац, чадавхийн хэмжээг төсөл хэрэгжүүлж эхлэхийн өмнө өөрийн хөрөнгөөр байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын гаргасан удирдамж, чиглэлийн дагуу мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, төлбөрийг улсын төсөвт шат дараатайгаар дээрх үнэлгээний хэмжээтэй адилаар төлж барагдуулна.

### **Тав. Дэд бүтэц**

- 5.1 Хөрөнгө оруулагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийн асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### **Зургаа. Хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүч**

- 6.1. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 6.2. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд оролцож, түүнтэй хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажиллаж байгаа Монгол Улсын иргэд хуулийн дагуу шаардагдах нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдана.
- 6.3. Хөрөнгө оруулагчийн Монгол Улс дахь үйл ажиллагаанд оролцож байгаа гадаадын иргэд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд сайн дураараа хамрагдаж болно.
- 6.4. Хөрөнгө оруулагч нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахдаа Монгол Улсын Засгийн газраас тогтоосон тухайн жилийн гадаадаас авах ажиллах хүчний квотыг мөрдөнө.
- 6.5. Хөрөнгө оруулагчид гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө төлөх ажлын байрны төлбөрийг энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацааны турш энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөж байсан хууль тогтоомжид заасан хэмжээгээр ногдуулна.
- 6.6. Хөрөнгө оруулагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүйн ажиллагааны стандартыг мөрдөнө.

### **Долоо. Хөрөнгө оруулагчийн эрх үүрэг**

- 7.1. Хөрөнгө оруулагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 7.2. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид олгодог эрх, нөхцөлөөр адил хангагдана.
- 7.3. Хөрөнгө оруулагч нь өөрийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.
- 7.4. Хөрөнгө оруулагч нь Монгол Улс болон гадаад орны банкинд данс нээж өөрийн сонгосон валютаар чөлөөтэй, саадгүйгээр гүйлгээ хийж болно.
- 7.5. Энэхүү гэрээгээр жил бүрийн 8 дугаар сарын 1-нээс дараагийн жилийн 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг “хөрөнгө оруулалтын жил” гэж үзнэ.
- 7.6. Хөрөнгө оруулагч нь энэхүү гэрээ байгуулагдах үед 16.5 тэрбум төгрөгийн анхны хөрөнгө оруулалтыг Монгол Улсад оруулсан байгаа болно. Хөрөнгө оруулагч энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Монгол Улсад 10

жилийн хугацаанд нийт 100.0 сая ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалтыг дараахь хуваарийн дагуу хийнэ.

Жил	Хөрөнгө оруулалтын жил	Хөрөнгө оруулалтын дүн ам. доллар	Мөнгөн тэмдэгтээр	Бусад хууль тогтоомжийн дагуу
1	2007 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2008 оны 7 сарын 31-ний өдөр хүртэл	5 сая ам. доллар		
2	2008 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2009 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	5 сая ам. доллар		
3	2009 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2010 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
4	2010 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2011 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
5	2011 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2012 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
6	2012 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2013 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
7	2013 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2014 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
8	2014 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2015 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	10 сая ам.доллар		
9	2015 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2016 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	15 сая ам.доллар		
10	2016 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2017 оны 7-р сарын 31-ний өдөр хүртэл	15 сая ам.доллар		
	<b>Хөрөнгө оруулалтын нийлбэр дүн</b>	100 сая ам.доллар		

- 7.7. Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайлангаа дараагийн хөрөнгө оруулалтын жилийн эхний сард багтаан Сангийн яамны баталсан маягтын дагуу гаргаж, тухайн салбарын болон бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан Сайдад хүргүүлнэ.
- 7.8. Хөрөнгө оруулагч нь санхүүгийн тайлангийн аудитыг олон улсын болон Монгол Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн аудитын компаниар хийлгэсэн байна.
- 7.9. Хөрөнгө оруулагч бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогын талаарх мэдээллийг үнэн зөв гаргаж өгнө.
- 7.10. Хөрөнгө оруулагч нь бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа бүтээгдэхүүн, оюуны өмчийн болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад байдлаар хөрөнгө оруулалт хийх эрхтэй.
- 7.11. Сайд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас энэхүү гэрээний баталгаа алдагдсан тохиолдолд Хөрөнгө оруулагч баталгааг сэргээлгэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуулиар заасан журмын дагуу шаардлага, нэхэмжлэл гаргах эрхтэй.

#### **Найм. Сайдын эрх, үүрэг**

- 8.1. Сайд нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн болон санхүү, татварын орчныг энэхүү гэрээний хугацааны турш тогтвортой байлгах талаар энэхүү гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хөрөнгө оруулагчийг хангах үүргийг хүлээнэ.
- 8.2. Сайд нь энэхүү гэрээнд гарын үсэг зурсны дараа энэхүү гэрээний нөхцөл болон заалтын тухай мэдэгдлийг холбогдох газруудад хүргүүлнэ.
- 8.3. Хөрөнгө оруулагч нь 7.6 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө оруулалт хийх болон энэхүү гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлээгүй 6 сар өнгөрвөл Сайд энэ тухай Хөрөнгө оруулагчид албан бичгээр мэдэгдэл өгнө.
- 8.4. Мэдэгдэл өгснөөс хойш ажлын 120 хоногийн дотор Хөрөнгө оруулагч уг мэдэгдэлд заасан үүргийг биелүүлэх талаар зохих арга хэмжээ аваагүй тохиолдолд Сайд энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.

#### **Ес. Хөрөнгө оруулагчийн эрх зүйн хамгаалалт**

- 9.1. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон буюу соёрхон баталсан олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалттай байна.
- 9.2. Хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглоно.

- 9.3. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү хүчин төгөлдөр хуульд заасан үндэслэлээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан гаргуулж болно.
- 9.4. Хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжид олгодогтой адил тааламжтай нөхцөл олгоно.

#### **Арав. Гэрээ дуусгавар болох**

- 10.1. Дараахь тохиолдолд энэхүү гэрээ дуусгавар болно:
- 10.1.1 Энэхүү гэрээний хугацаа дууссан тохиолдолд,
- 10.1.2 Энэхүү гэрээний үүргийг бусдад шилжүүлсэн тохиолдолд,
- 10.1.3 Хөрөнгө оруулагч энэхүү гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу хоёр тал бичгээр харилцан тохиролцсон тохиолдолд,
- 10.1.4 Хөрөнгө оруулагчийн Аж ахуйн нэгж дампуурсан эсвэл хууль тогтоомж зөрчсөний учир эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон тохиолдолд болон Сайд албан мэдэгдэл хөрөнгө оруулагчид өгснөөс хойш ажлын 120 өдрийн дотор тухайн дампуурал эсхүл хууль тогтоомжийн зөрчлөө арилгаагүй тохиолдолд,

#### **Арван нэг. Давагдашгүй хүчин зүйл**

- 11.1. Дайн, газар хөдлөлт гэх мэт байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчин болон бусад давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүгдийг, эсхүл аль нэгийг биелүүлээгүй бол ийнхүү биелүүлээгүйн улмаас гарах үр дагаварт талууд хариуцлага хүлээхгүй.

#### **Арван хоёр. Маргааныг шийдвэрлэх**

- 12.1 Энэхүү гэрээний үүргийн биелэлтэй холбогдон үүссэн аливаа маргааныг дор дурьдсанаар шийдвэрлэнэ.
- 12.1.1 Маргааны талаар нөгөө талд бичгээр хандаж мэдэгдэл гаргана. Талууд уг маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 12.1.2 Хэрэв талууд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд Монгол Улсын Арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 12.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаантай асуудлыг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын бүхий л хууль тогтоомжийг хэрэглэнэ.

#### **Арван гурав. Бусад зүйл**

- 13.1. Энэхүү гэрээ нь Засгийн газрын холбогдох байгууллагуудтай бие даан үйл ажиллагааны гэрээ хийх хөрөнгө оруулагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 13.2. Энэхүү гэрээг 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод Монгол, Англи, Япон хэл дээр тус тус үйлдэж, баталгаажуулав.

- 13.3. Хувиуд адил хүчинтэй байна. Хэрэв гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахад маргаан гарвал Монгол хэл дээрх эх бичвэрийг баримтална.
- 13.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 13.5. Оролцогч бүх тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно.


**Гэрээ байгуулсан талууд:**


**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:**

**“СУРУГА МОНГОЛ” ХХК-ИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

**“СУРУГА МОНГОЛ” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**

  
**Н. БАЯРТСАЙХАН**

  
**ИВАТА ЦУЁШИ**